

**“Монголын Нууц Товчоон”-ы уйгуржин
монгол эхийг сэргээх тухайд**

Ш.Чоймаа (МУИС)

“Монголын Нууц Товчоон” болбоос агуулга, хэмжээ өргөн дэлгэр, үгийн сангаар арвин баялгийн зэрэгцээ уйгуржин монгол бичгийн эртний зөв бичихзүй болон дундад үеийн монгол хэлний ялангуяа дорнод монголын аялгууны онцлогийг тун тодорхой тусгасан хосгүй гайхамшигт сурвалж бичиг юм.

“МНТ”-ны судлал нь Монгол судлалын биеэ даасан салбар ухаан болтлоо хөгжиж, олон орны үе үеийн судлаачдын оюун ухаанаар зохих асуултыг бодит баримтаар тодлосоор байгаа билээ. “МНТ”-ныг олон талаас нь гүнзгийрүүлэн судлах тусам анхны эх бичигтээ ямар үг, үсэг байсан бол, эртний монгол үсгийн ямархан хэв хэлбэрээр бичсэн бол, тухайн үгийг хятадаар галиглагч хир зөв уншсан бол гэх зэрэг ээдрээтэй асуултад тулж очно.

**I. “МНТ”-ны уйгуржин* монгол эхийг сэргээхэд
латин галиг эхүүдийн үүрэг**

14 дүгээр зууны сүүл үед, хятад хүнийг монгол хэлд сургах зорилгоор, уйгуржин монгол бичгээр анх зохиогдсон “МНТ”-ны үг бүрийг хятад ханз үсгээр авиачлан галиглаж, хажууд нь хятад орчуулга хадаж, бас зүйл хэсэг бүрийн эцэст ерөнхий товч агуулгын орчуулга хийсэн “МНТ”-ны ийм л эх бидэнд хүрч ирснийг судлан шинжилсээр, улмаар хятад галиг эхийг латинаар галиглан буулгах, урьд хожид хийснийг улам улам сайжруулах нэр их ажлыг дэлхийн “МНТ” судлаач эрдэмтэд олон жил уйгагүй хийж, судалгааны өндөр төвшинд хүрсэн нь “МНТ”-ны судлалд асар том түлхэц болсон юм. Өөрөөр хэлбэл, эртний хятад үсэг мэдэхгүй судлаач нар “МНТ” хэмээх гайхамшигт зохиолын эх бичигт халдан очих сайхан боломж бүрдсэн юм.

Латин галигаар сэргээсэн тухайд, Өвөр Монголын нэрт эрдэмтэн Ихмянгадай Иринчин гуай **“Латинчилсан галигийг Нууц Товчооны сэргээлтийн ажлын анхны алхам хэмээгүүштэй. Эрих Хейниш гучаад онд латин галиглал нийтэлсэн бөгөөд үүнийг эхний сорилт хэмээлтэй”**¹ гэж өгүүлсэнтэй санал нэг байна.

“МНТ”-ны уйгуржин монгол эхийг сэргээн тэнхрүүлэхэд түшиглэх гол тулгуур бол дэлхийн алдартай, ач буянтай эрдэмтдийн бүтээсэн латин галиг эхүүд юм. E.Haenisch (1935), Hattori Shirō (1939), S.A.Kozin (1941), Shiratori Kurakichi (1942), P.Pelliot (1949), L.Ligeti (1964), I de Rachewiltz (1972), Bayar (1980), Ozawa Shigeo (1984-89), T.Dašceden (1985), B.Sum'yabaatar (1990), J.C.Street (1997), Kuribayashi Hitoshi, Choijinjab (2001), Šongqur (2002) гэх мэт эрдэмтний

* Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн монгол бичгийн дурсгалыг уйгуржин монгол бичгээр бичсэн гэж үзэж ийнхүү нэрлэж байгаа болно. Харин 16 дугаар зуунаас хойш, ялангуяа их хэмжээгээр модон бараар ном хэвлэх үед монгол бичгийн хэл яах аргагүй бүх талаар тогтсон хэм хэмжээтэй болсон билээ.

¹ mongyol-un niyuča tobčiyān, Yekeminyadai irinčin-ü sergügelte, Kökeqota, 1987, 25 дугаар тал

латин галигаар сэргээсэн эхүүд судлаачдын хүртээл болсон билээ. Бид юуны өмнө эдгээр судлаачдын латин галиг эхүүдийг харьцуулан үзэх ёстой. Учир нь тэдгээр бүх судлаач урьд нь хэвлэгдсэн латин галиг эхүүдийг үзэж, хятад эхтэй тулган нягталж, өөрийн галигласан арга барилаа, судласан байдлаа бичсэн байдаг.

Бас нэг тэмдэглэх зүйл "МНТ"-ны латин галиг эхийг бүтээсэн эрдэмтэд эртний хятад хэлд сайн мэргэшсэн судлаач байсан тул тэдний судалгаанд итгэх бүрэн боломжтой юм.

"МНТ"-ны хятад галиг болон латин галиг эхийг ашиглан, анхны уйгуржин монгол эхийг сэргээхдээ анхаарах зүйл гэвэл:

1. Бидний ашиглаж судалгаандаа хэрэглэж байгаа "МНТ"-ны латин галиг эхүүд нь хятад галиг эхийг л үнэн зөв сэргээхэд чиглэсэн байдаг.
2. "МНТ"-ны хятад галиг, түүнийг үнэн зөвөөр буулгасан латин галиг хоёрын аль аль нь дундад үеийн монгол хэлний онцлог тухайлбал 14 дүгээр зууны сүүл үеийн дорнот Монголчуудын аман аялгууны онцлогийг л тусгасан. Энэ нь Мин улсын хааны зарлиг, зохиолгосон зорилготой ч нийцэж буй. Ийм учраас "МНТ"-ны галиг эхээс, эртний монгол хэлний онцлог, уйгуржин монгол бичгээр бичигдсэн анхны эхийн онцлог шинж тэргүүтнийг бүрэн үзэж мэдэх боломжгүй гэсэн үг.
3. Алдаа судлалын үүднээс байнга анхаарч бодох ёстой. "МНТ"-ны судлалд хосгүй гавьяатай Японы профессор Ш.Озава "**13 дугаар зууны монгол хэлийг тэмдэглэсэн энэхүү хятад үсгүүд нь туйлын тодорхой мөртөө нарийлагаар, тухайн үеийн монгол хэлийг илтгэсэн боловч, хүний гараар бичигдсэн юм болохын учир түүнд буруу бичсэн, орхигдуулсан, давхардуулсан зэрэг зүйл үзэгдэж байх нь ч бас ерийн хэрэг болно**"² гэж бичсэн нь "МНТ"-ыг судлахдаа "алдаа судлал" (Etymology)-ын үүднээс анхаарах хэрэгтэйг сануулсан хэрэг юм. Энд бид сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн зөв бичих зүй, бичгийн тогтсон хэв зурлага хийгээд эртний монгол хэлний гол онцлогоор хэмжүүр болгон, тухайн хэсгийн утга агуулга, учир зүйгээр хашин бодож, алдаа мөн эсэхийг тодолно.

Тэрхүү "алдаа" нь хэд дахин давтагдвал тухайн эхийн текстологийн судалгаанд анхааран үзэх зүй тогтолтой зүйл байж болдог. Ганц жишээ дурдахад, профессор Ш.Озава "МНТ"-ны 169 дүгээр зүйлийн хятад галигаас нэгэн өгүүлбэрийг авч, Лу. "Алтан товч"-ийн тохирох хэсэгтэй харьцуулан судлаад,

[SHM]	Narin = geyēn basa adūci-da'an KišiliG-a ügülerün
[LAT]	Narin = gegēn basa aduGūci KišiliG-a ügüler-ün
[SHM]	Merkidei = čaGa`ān Aman = čaGa`ān ke`ēr qoyar-i
[LAT]	Merged = dei = čaGa`an Aman = čaGa`ān kegēr qoyar-i
[SHM]	bariju abčira. huyaju söni erte morilaqu ke`ejü`üi
[LAT]	bariju abču ire uyaju ene söni erte morilasu kemejügüi>> ³

Ингэж харгуулан үзвэл "Нууц Товчоон"-ы хятадаар галигласан уул зохиол болон Лу. "Алтан товч" нь гайхмаар адилхан байна. Энэ хоёрын ноцтой зөрөө нь "morilaqu"-тай тохиролцох "morilasu" болно. Хойно өмнөх үгийн харьцаанаас үзвэл Лу. "Алтан товч"-ийн "morilasu" зөв болох нь тодорхой байна.

"МНТ"-ны хятад галиглалын энэ мэт алдаа нь уг зохиол нь уйгуржин монгол үсгээр бичигдсэнээс л үүсч болно"⁴ гэж бичжээ. Сонгодог бичгийн өмнөх үеийн монгол

² Ozawa Sigeo, mongyol-un niyuča tobčijan-u yirtinčü, *borjigin Bayarmendü orčiγulba*, ОМАКQ, Kōkeqota, 1980, 38 дугар тал-а

³ "МНТ" болон Лу. "Алтан товч"-ийн латин галиг, нэмэлт зэргийг номд бичсэн хэвээр нь буулгав.

дурсгалд “s” болон “q” үсгүүд, үгийн эхэн болон дунд дүр хэлбэрийн хувьд тун адилхан бичдэг бөгөөд түүнээс үүдсэн алдааны нэг нь энэ юм. Нэгэнт ийм “алдаа” байдгийг мэдвэл, түүний мөрөөр “МНТ”-ны хятад галиглагчийн эндүүрсэн цөөнгүй алдааг олж, залруулж болно. Жишээ: “МНТ”-162 дугаар зүйлд “...tere so`or-tur...”⁵, 172 дугаар зүйлд “...so`or cölo`tür”⁶ гэж хятадаар галигласан бол Лу. “Алтан товч”-ийн тохирох хэсэгт “tere qoyur-tur” (тэр хооронд), “qoyur cöle-tür” (хоор чөлөөнд) гэж зөв уншжээ. Мөн “МНТ”-ны 124 дүгээр зүйлд: Сүбээдэй баатрын хэлсэн үгийг:

“... quluqana bolju quriya[.]dusu qara ker`e bolju qada`un бүгүн-i qarmaldusu nembe`e isgei bolju nemürleldün **so^{ri}su** gerisge isgei bolju ger jük gerisgeleldün **so^{ri}su** ke`eba”⁷ (Хулгана болж хураалдсу. Хар хэрээ болж, гадуун (гадуур) бүхийг хармалдсу. Нөмрөг эсгий болж, нөмрөлдөн сорису. Хэрсэг эсгий болж, гэр жүг (гэр барааг, гэр ачааг) хэрсэглэлдэн сорису хэмээв) гэж хятадаар галигласныг судлаачид латин үсгээр мөн адил буулгасан байдаг. Энэхүү хэсэгт хоёр удаа гарах “**so^{ri}su**” хэмээх үг нь “qorisu” (хорису ~ хорьж хамгаалья) гэсэн үг болох нь Лу. “Алтан товч” болон тухайн хэсгийн логик утгаар зөв тодорхой байдаг. “хорих”, “сорих” гэсэн хоёр үг утгын их ялгаатай үг шүү дээ. Ташрамд дурдахад, XIII зууны үе болон бүр эртний түрэг хэлэнд “хорих” гэдэг үг нь “хамгаалах” гэсэн гол утгатай байсан. Зөвхөн “s”, “q” үсгийг эндүүрсэн тухай дээрх жишээгээр адилтган бодож, “МНТ”-ны хятад болон латин галиг эхийг нягтлан судалбал утгын мадаг арилж, урьд өмнх орчуулгуудыг ч засах хэрэгтэй болно.

“МНТ”-ны хятад галиг, түүнийг буулгасан латин галиг эхүүдийн тухай өмнө өгүүлсэн зүйл бол урьд хождын гайхалтай бүтээлүүдийг шүүмжлэх гэсэн хэрэг бус харин “МНТ”-ны уйгуржин монгол анхны эхийг сэргээн сийрүүлэхэд анхаарах зарим санамж юм.

II. “МНТ”-ны уйгуржин монгол эртний эхийг сэргээхэд Лувсанданзаны “Алтан товч”-ийн үүрэг

Хэн бүхний мэдээжээр, 1926 онд олдож, 1937 онд Улаанбаатарт 2 дэвтрээр хэвлэгдэж, жинхэнэ эхийг 1990 онд гэрэл зургийн аргаар хэвлэсэн Лувсанданзаны “Алтан товч” бол “МНТ” судлаач хүн бүхний ширээний ном болсон билээ.

Миний бие 2002 онд, “Монголын Нууц Товчоон”, Лувсанданзаны “Алтан товч”-ийн эхийн харьцуулсан судалгаа” хэмээсэн бүтээлээ Улаанбаатарт хэвлүүлсэн. Уг зохиолынхоо удиртгалд Лу. “Алтан товч”-ийн судлагдсан байдлын тухай дэлгэрэнгүй өгүүлсэн тул энд дахин нурших хэрэггүй билээ. “МНТ”-ны уйгуржин монгол эртний эхийг сэргээхэд Лу. “Алтан товч” ямар ач тустай болохыг профессор Ихмянгадай Иринчин “Сэргээлт хийхэд...нэг гол дулдуу (түшиг, тулгуур – Ш.Ч.) гэвэл Лу. “Алтан товч” юм. Лувсанданзаны бичигт (“Алтан товч”-д - Ш.Ч.) Нууц Товчооны зонхи хэсэг (282 зүйлээс бараг 233 зүйл нь Ш.Ч.) хуулагдан орж, нэлээд бичлэг нь Нууц Товчоо лугаа эгээ (яг) адил. Түүнчлэн Лувсанданзаны ташаатай хуулал, буруу өөрчлөл нь ч Нууц Товчооны уг эхийн байдлыг мэдэхэд ором мөр болж өгдөг. Жишээлбэл: <<baɣdad>> (ᠪᠠᠭᠳᠠᠳ) хотыг Лу. “Алтан товч”-д ᠪᠠᠭᠳᠠᠳ (ᠪᠠᠭᠳᠠᠳ) гэж цалгай бичсэнээс уйгуржин эхэд нь чухамдаа ᠪᠠᠭᠳᠠᠳ (baɣdad) гэж байсныг мэдэж болно...”⁸ гэж өгүүлсэн байдаг.

“МНТ”-ны Лу. “Алтан товч”-той тохирох зүйл хэсгийг үг үсгээр нь харгуулан судлахад, “МНТ”-ны уг эх нь уйгуржин монгол бичгээр зохиогдсон хийгээд тэрхүү анхны монгол эх нь

⁴ Ozawa Sigeo, *mongyol-un niyuca tobciyan-u yirtinöü, borjigin Bayarmendü orciyulba*, ОМАКQ, Kökeqota, 1980, 38, 39 дугаар тал-а

⁵ Ш.Чоймаа, “Монголын нууц товчоон” Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002, 110 дугаар тал

⁶ Ш.Чоймаа, “Монголын нууц товчоон” Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002, 123 дугаар тал

⁷ Igor de Rachewiltz, *Index to the Secret history of the Mongols*, Bloomington, 1972, p. 52, 53

⁸ Yekeminyadaï irinčin-ü sergügelte, *Mongyol-un niyuca tobciyan, Öbör Mongyol-un yeke surayuli-yin keblel-ün qoriy-a*, 1987, 39, 40 дүгээр тал-а

хуулбарлагдан үе дамжин хадгалагдсаар 17 дугаар зуун лав хүрчээ гэсэн дүгнэлтэд өөрийн эрхгүй хүргэдэг.

Энэ тухай профессор Ш.Озава **“Одоо бидэнд байгаа “Нууц Товчоон”-ы уул зохиол нь уйгуржин монгол үсгээр бичигдсэн уг эхэд суурилж, хятадаар галиглагдсан гэдэг нь тодорхой байгаа мөртөөн Лу. “Алтан товч”-ийн зохиогч Лувсанданзанд, уйгуржин монгол үсгээр хуулагдсан “Нууц Товчоон”-ы нэг дэвтэр байсан гэдэг нь ч одоо хүртэлх судалгаанаас тодорхой боллоо. Лувсанданзанд байсан арван долдугаар зууны сүүлийн хагас хүртэл “Нууц Товчоон”-ы уйгуржин монгол үсгийн дэвтэр бас үлдэж байсан байна”**⁹ хэмээснийг одоо дэлхийн монголч эрдэмтэд хүлээн зөвшөөрөхийн хамт, “МНТ”-ныг Лу. “Алтан товч”-той харьцуулан судлахыг чухалчилдаг боллоо.

“МНТ”-ны уйгуржин монгол эхийн сэргээлтэд Лу. “Алтан товч”-ийг ашиглахдаа санаж байх зүйл гэвэл:

1. 17-р зууны түүхч Лувсанданзанд урьд өмнө нь засаж өөрчлөөгүй нэлээд эртний, элж хуучирсан “МНТ”-ны нэгэн эх хуулбар байсан гэдэг нь уг хоёр сурвалжийн харьцуулсан судалгаанаас аяндаа мэдэгдэнэ. Лувсанданзан болон түүний бичээч нар хэдийгээр бичгийн хүмүүс байсан боловч 13 дугаар зууны үеийн монгол үг хэллэг, бичлэгийн хэв маяг, эртний монгол хэлний хэлзүй, найруулгын онцлог зэргийг бүрэн гүйцэд ухан мэдэхэд тун хэцүү байсан тул алдаа ташаа нэлээд байх нь зүйн хэрэг билээ.

2. Лувсанданзан бээр тухайн үеийн сонгодог монгол бичгийн хэлэнд ойртуулах гэж бага сага найруулгын засвар хийсэн нь илт мэдэгдэх бөгөөд “МНТ”-ны эртний эхийн дийлэнх хэсгийг тун өчүүхэн өөрчлөлттэйгээр бидэнд хуулж үлдээсэн хосгүй гавьяатай гүүш юм. Хэрэв Лувсанданзан хамаагүй ихээр өөрчилсөн бол Лу. “Алтан товч”, “МНТ”-ны судлалд өнөөгийнх шиг эрхэмлэгдэхгүй байсан билээ.

3. Гол нэг онцлог бол хятадаар монгол үгийг галигласан 14 дүгээр зууны эхтэй харьцуулбал Лувсанданзан эртний уйгуржин монгол бичгээс, хожуу үеийн сонгодог бичгийн хэв хэлбэрээр буулган бичсэн явдал юм. Өөрөөр хэлбэл хятадаар галигласан “МНТ” бол уйгуржин монгол бичгээр байсан эхийг 14-р зууны дорнод Монголын аялгуутан хүн бээр дуудлагаараа буулгасан эх, харин Лувсанданзаны “Алтан товч” бол “МНТ”-ны уйгуржин монгол бичгээр байсан эхээс монгол бичгээрээ бичсэн бүтээл бөгөөд цаг хугацааны хувьд их зайтай бичсэн ч хоёул монгол бичгээр байсан хэрэг. Хамгийн хэрэгтэй, судалгааны үнэ цэнэтэй тал нь ч энэ юм. Ийм учраас, сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үеийн дурсгалын хэлбичгийн онцлогоор Лу. “Алтан товч”-ийг судлах боломж бидэнд олдож байна.

4. Лу. “Алтан товч”-ийг “МНТ”-ны галиг эхтэй үг үсгээр тулган харгуулах явцад “МНТ”-ны эртний уйгуржин монгол эхийн бичлэгийн зарим гол онцлог тодорч, “МНТ”-ны анхны уйгуржин монгол эхийг сэргээхэд их зүйлийг тодолж өгнө. Энэ нь зөвхөн үсэгзүйн хүрээнд бус хэлзүй, үгзүйн төвшинд ч хамаарна.

5. “МНТ”-ны уг эхэд яах аргагүй байсан үг хэллэгийг хятад галигт орхигдсоныг нөхөн сэргээх боломжтой. Гэхдээ олон талаас судалж лавтай орхигдсон үг хэллэг мөн болохыг батлах ёстой. Бас хятадаар галиглагчийн ташаарлыг залруулахад Лу. “Алтан товч” голлох үүрэгтэй. Лу. “Алтан товч”-ийн тухайд дүгнэн өгүүлэхэд, нэрт монголч Л.Лигетийн бичсэнчлэн **“Лувсанданзан XIII зууны зөв бичихзүй болон хэлний онцлогийг хадгалсан “МНТ”-ны уйгуржин монгол үсгийн гар бичмэлийг ашигласан”**¹⁰ (Lubsangdanjin used a manuscript of Secret History which preserved the orthographic and linguistic characteristics of the 13th century original in Uighur script) тул “МНТ”-ны уйгуржин монгол эхийг сэргээхэд хамгийн гол түлхүүр хэрэглэгдэхүүн юм.

⁹ Ozawa Sigeo, *mongyol-un niyuča tobčiyān-u yirtinčü, borjigin Bayarmendü orčiyulba*, ОМАКQ, Kökeqota, 1980, 46 дугаар тал-а

¹⁰ Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*, Leiden Boston, 2004, p. Ivii


III. "МНТ"-ны уйгуржин монгол эхийг сэргээхэд, сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалыг судлахын ач тус

1987 профессор Ихмянгадай Иринчин бээр "МНТ"-ны уйгуржин монгол бичгийн нэгэн сайн сэргээлт хийж нийтлүүлсэн билээ. Ялангуяа түүний бичсэн дэлгэрэнгүй удиртгал нь тун олон учир шалтгааныг хөндөн тайлбарласан байдаг. Тэрбээр удиртгалдаа бичихдээ **"Урьдынхны зуу гаруй жилийн олон талын судлалын буурин дээр Нууц Товчооны уйгуржин монгол эхийг сэргээх явдал одоо биелэгдэх бололцоотой болж эхэлсэн. Энэ ажил латинчлан галиглахаас ч хол бэрх. Латинчлалд цалгар (эндүүрч ташаарсан) үсгүүдийг зассаны суурин дээр хятад үсгийн авиаг хөрвүүлэн, монголжуу галиглаад чадвал, төгс амжилтдаа хүрчихнэ. Гэтэл уйгуржин монголоор сэргээхэд, үүнээс хол илүү болзлууд шаардагдана.**

Сэргээлт хийхэд, уйгуржин монголын эхний үеийн зөв бичлэгтэй зөрөөгүй байх ёстой. Монгол хаанлиг (Их Монгол улсын үе – Ш.Ч.) болон Юань улсын үеийн уйгуржин бичгийн дурсгалууд одоо өдий төдий үлдэж ирсэн. Эдгээрийг сайтар судалж эзэмших нь юунаас ч чухал"¹¹ гэж бичсэн нь өөрийн биеэр "МНТ"-ны уйгуржин монгол сэргээлт хийсэн эрдэмтний үзэл баримтлал бөгөөд үнэхээр 13-15 зуун хүртэлх үеийн монгол бичгийн дурсгалыг судлахгүйгээр "МНТ"-ны уйгуржин монгол бичгийн сэргээлт хийнэ гэдэг сэтгэшгүй хэрэг юм.

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын үсэгзүйн зарим онцлог гэвэл:

1. Үгийн тэргүүн үед "е" эгшиг үсгийг "а"-тай адил титэмтэй бичдэг нэлээд тогтсон зуршилтай байсан. Жишээлбэл:



гэх мэт.

Лувсанданзаны "Алтан товч"-ийг "МНТ"-ны галиг эхтэй харьцуулан үзэхэд, "МНТ"-ны уйгуржин монгол эх бичигт дээрх онцлог хадгалагдаж байсны цөөнгүй баримт олддог. Энэ тухай судлаачид (И.Иринчин, Ш.Озава, Шонхор зэрэг) тодорхой бичсэн бөгөөд профессор Ихмянгадай Иринчин, Шонхор нар өөрийн туурвисан "МНТ"-ны уйгуржин монгол үсгийн сэргээлтдээ, үгийн эхний "е" эгшигийг цөмийг "а"-тай адил титим шүдээр бичсэн байдаг.

Бид өөрсдийн хийж байгаа сэргээлтдээ энэ зарчмыг баримтласангүй. Учир нь, хэдийгээр "МНТ"-ны уйгуржин монгол эртний эхэд тийм бичлэгтэй үгс байсан нь судалгаанаас тодорхой байгаа боловч, бүх зохиолын "е"-гээр эхэлсэн бүх үг тийм бичлэгтэй байгаагүй нь лавтай. Учир нь сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалуудад ийм бичлэгтэй жишээ харьцангуй цөөн тохиолддог. Бүх л "МНТ"-ныг ингэж бичвэл нэгэн зүйлийн хэтрүүлэл болох болно.

2. Үгийн эхний "j" (ᠵ) "y" (ᠶ) болон үгийн дунд орсон "i" (ᠶ) цөм адил нэгэн шилбэ байсан. Мөн үгийн дунд орсон "č" (ᠴ), "j" (ᠵ) хоёр адилхан бичлэгтэй байсны дээр зарим үед "r" (ᠷ) үсгийн өвөрмөцхөн бичлэгтэй ч эндүүрэм байдаг.

¹¹ Yekeminyadai irinčin-ü sergügelte, *Mongyol-un niyuča tobčiyan, Öbör Mongyol-un yeke surγayuli-yin keblel-ün qoriy-a*, 1987, 34, 35 дугар тал-а


Бас үгийн эхэнд, дунд орсон "s", "q" үсгүүдийн дүр байдал тун адил бичдэг байсан тул үүнээс үүдсэн "МНТ"-ны алдаа мадагийг өмнө профессор Ш.Озавагийн тайлбарласнаар жишээлэн дээр өгүүлсэн.

3. Эртний уйгуржин монгол бичгийн "t", "d" нь үгийн эхэнд ч, үгийн дунд ч ялгаатай байсан бөгөөд хожим үгийн дунд тохиолдох "t" (𐰃) үсгийн толгойг урагш оруулан, одоогийн үгийн дунд ордог дэвсгэр "d" (𐰃) үсэг шиг бичиж, "t"-гээр дуудаж байжээ. Хожим энэ нь монгол бичгийн үгийн дунд тохиолдох дэвсгэр "d" үсэг буй болсон билээ.

"МНТ" болон Лу. "Алтан товч"-ийн харьцуулсан судалгаанаас үзэхэд, үгийн дунд тохиолдох "t" үсгийг, гэдэс, шүд буюу <<𐰃>> ийм хэлбэрээр тэмдэглэсэн нь цөөнгүй байжээ. XIII, XIV, XV зууны уйгуржин монгол бичгийн дурсгалуудыг шүүн үзэхэд ийм бичлэг түгээмэл юм. Гэтэл "МНТ"-ны эхийг сэргээхэд үүнийг ямар хэмжээнд хэрэглэх вэ? гэдэг асуулт гарна. "МНТ"-ны сэргээлтдээ, бидний одоохондоо баримталсан зарчим бол сонгодог монгол бичгийн өмнөх үед тухайн үгийн онцлог бичлэг хэр зэрэг түгээмэл байсан бэ гэдгээр баримжаалах ёстой. Нэгэн жишээ дурдахад бид "МНТ"-ны сэргээлтдээ "metü" гэдгийг үгийг 𐰃 буюу 𐰃 хоёрын алинаар бичсэн бэ? гэвэл 𐰃 гэж бичлээ. Учир нь бид Сажа бандид Гунгаажалцаны зохиосон "Субашид" зохиолыг 14 дүгээр зуунд орчуулсан Тарнич тойн Соном-гара-гийн монгол орчуулгыг шүүн үзэхэд, 𐰃 гэж бичсэн тохиолдол 20, 𐰃 гэж бичсэн нь 25 удаа тохиолдож байна. Тэгвэл XIII зуунд 𐰃 гэсэн бичлэгийн хэлбэр улам илүү давамгай байсан байх учиртай тул, "МНТ"-ны одоогийн сэргээлтдээ "metü" гэсэн үгийг 𐰃 гэсэн хэлбэрээр бичсэн болно.

4. Үгийн эцсийн дэвсгэр "s" үсгийг богино сүүлээр (𐰃), үгийн төгсгөлд тохиолдох дэвсгэр "n" болон өмнөх үгтэй нь хамт бичих "a", "e" эгшгийг босоо сүүлээр бичдэг байсан бөгөөд "a", "e" эгшгийг салангид бичих нь тун цөөн байжээ. Энэ нь мөн л "МНТ"-ны уйгуржин монгол эхэд холбогдоно. Холбогдохын учир нь зөвхөн сэргээлт хийхэд төдийгүй "МНТ"-ны зарим үгийн өнөө хүртэл зөв хэмээн үзэж байгаа үгийн хэлбэрийг өөрөөр ойлгоход туслана.

5. Монгол хэлний түүхэн хэлзүйг судалсан эрдэмтэд, **эртний монгол хэлний үед, хэлэгдэх хүчдэлийнхээ талаар харилцан бие биетэйгээ эсрэгцэлдсэн найман богино эгшиг фонем байжээ**¹² гэж үздэг. Энэ үзэл онолын гол үндэс нь сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалуудад эр буюу чанга үгэнд тохиолдох "i" эгшгийн өмнө "q", "γ" тогтвортой бичигдсэн байдаг. Тодорхой жишээ болгож, 1312 оны Чойжи-Одсэр (C'os-kyi `Od-zer)-ын зохиосон "bodhstw çary-a awatar-un tayilbur"-ийн модон барын хэвлэлээс эш татъя¹³:



(Хязгааргүй тахилын үүлдээр (үүлсээр), явагчин багшийг тахихун болтугай).

Энд эш татсан жишээ өгүүлбэрт "qijayalal, taqil, taqiqun" гэсэн үгийг, сонгодог монгол бичгээр бичвэл "kijayalal, takil, takiqun" гэж бичнэ. Үүнээс үзвэл, эртний монгол хэлэнд, өмнөх

¹² Д.Төмөртоогоо, **Монгол хэлний түүхэн хэлзүйн үндэс, монгол хэлний түүхэн авиа зүй, I дэвтэр**, Улаанбаатар, 1992, 3-4 дугаар тал

¹³ E.Haenisch, **Mongolica der Berliner Turfan-Sammlung, I, Eine buddhistisches Druckfragment vom Jahre 1312**, 1954, Akademie-Verlag, Berlin.

гийгүүлэгчээ тагнайшуулдаггүй, хэлний хойгуур хэлэгддэг эр үгийн "г" байжээ. Бид "МНТ"-ны энэхүү сэргээлтдээ, эртний монгол хэлний энэхүү зүй тогтлыг баримталсан болно.

"МНТ"-ыг уйгуржин монгол эхээр нь сэргээсэн эрдэмтэд бараг цөм ямар нэг хэмжээгээр цэг дуслыг хэрэглэжээ. Бид үүнээс татгалзаж байгаа бөгөөд учир юун хэмээвээс, XIII зууны уйгуржин монгол бичигт байтугай бүр хожуу үеийн сонгодог монгол бичгийн модон барын олон зуун боть сударт нэг ч цэг дусал хэрэглээгүй байдаг.

Харин XIII, XIV зууны гар бичмэл судар номд, хувь хүн бээр бусдад уншихад хялбар болгохын үүднээс үл ялгарам газар ганц нэг цэг дусал тавьсан байдаг. Энэ бол XVI зуунаас өмнөх үед хамаарах нь мэдээж хэрэг боловч өнөө хэр, хамгийн анхны уйгуржин монгол бичгийн дурсгал гэж үздэг Чингисийн чулууны бичигт ганц нэг цэг байдгийг Монгол улсын нэрт түүхч Х.Пэрлээ энэ нь хожуу үед өөр хүн цохиж сийлсэн бололтой гэж бичсэн байдаг.

7. Бидэнд уламжилсан "МНТ" бол хятад хүнд монгол хэл сургахаар монгол үгийг хятадаар галиглуулан, хятадаар орчуулсан эх бичиг гэдгийг өмнө хэдэнтээ дурдсан. Гэхдээ уг эх зохиол бэлэн цээжилчихсэн аман зохиол мэтийг дуудан өгсөн бус, бас чамгүй эрт зохиогдсон түүхэн шастирыг XIV зууны үеийн монгол хүний хэл аялгуугаар дуудан, галигласан тул уйгуржин монгол бичгийн хэлний нөлөө илэрхий мэдэгдэнэ. "МНТ"-ны үг хэллэгийг "*Мухаддимат-ал-адаб*" тольтой харьцуулбал энэ санаа улам тод болно. Өмнө өгүүлсэн зүйлээс юу мэдэгдсэн бэ? гэвэл, өнөө "МНТ"-ны хятад галигаар уламжилсан "МНТ"-нд гарах нэг язгуурт үгс, хэлзүйн адил хувилал зэргийг өөр өөр хэлбэртэй бичсэн тохиолдож байгаа нь бас нэгэн баримтыг өгүүлж байна.

Мин улсын эхэн үед, зохиогдоод 100 хол илүү жил болсон "МНТ"-ныг уншиж, ойлгож, тухайн үеийн дорнот Монголын аялгуугаар хэлж өгнө гэдэг хэцүү ажил байсан. Ямар боловч, бидний ажигласнаар зарим үгийг тухайн үеийн дуудлагаар, зарим үгийг бичсэн бичлэгээр нь зохих хэмжээнд дагуулан хятадаар галиглажээ гэж хэлж болох юм. Зөвхөн энэ талаар нэг жишээ эш татъя:

Эртний монгол хэлэнд чанга хөндий буюу эр, эмээр зохицох ёсыг хатуу баримталж байсан боловч, уруулын талаар, зохицох ёс төдийлөн хөгжөөгүй байсаар, дунд үеийн монгол хэлний үед сая л уруулаар зохицох ёс алгуур буй болсныг "МНТ" гэрчилж байна.

Эртний монгол хэлэнд, үгийн I үеэс хойш богино, о, ө ер ордоггүй жамтай. Гэтэл "МНТ"-ны 226 дугаар зүйлд "urida ögele-cerbi-lü'e oroqsat turqa'ut de'ere minqan dü'ürgejü bo'orsu-yin uruq-asa ögele-cerbi medetügei ke'eba"¹⁴ гэж байхад 230 дугаар зүйлд: "ögöle-cerbi-lü'e oroqsat dalan turqa-i yekes turqa'ut ke'ekdün..."¹⁵ гэж гарч байх бөгөөд "ögöle-cerbi" гэж 5 удаа бичсэн бол "МНТ"-ны уйгуржин монгол эхэд байсан хэлбэрээр нь 2 удаа "ögele-cerbi" гэж бичжээ.

Бид эртний монгол хэлний зүй тогтоолоор үгийн I үеэс хойш богино "о", "ө" үл тохиолдох зарчмаар "МНТ"-ны хятад галиг, түүнд үндэслэсэн латин галигийг засаж, эртний уйгуржин монгол бичгээр сэргээн буулгаж байна.

Бас нэг зүйлийг тэмдэглэхэд, Мин улсын эхэн үед хятадаар галиглагчийн гарт байсан "МНТ"-ны эх ч, XVII зууны түүхч Лувсанданзаны гарт байсан "МНТ"-ны хувилбар ч аль аль нь элж хуучирсан тул зарим үсэг танигдахгүй болсон байсныг хүлээн зөвшөөрөх ёстой. Жишээлбэл: Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн бичлэгийн үгийн төгсгөлийн "г", "и" хоёрын бичлэг ялимгүй элэгдсэн л бол уншихад төвөгтэй. Үүнээс шалтгаалсан эндүүрэл "МНТ"-ны хятад галигт ч, Лу. "*Алтан товч*"-д тун элбэг тохиолдоно. Энэ талаар дэлгэрэнгүй мэдэх гэвэл, энэ өгүүллийг бичигч миний "*Монголын Нууц Товчоон*", *Лувсанданзаны "Алтан товч"-ийн харьцуулсан эхийн судалгаа*" (УБ 2002 он) номоос дэлгэрүүлэн үзнэ үү.

Бид "МНТ"-ны эртний монгол бичгийн эхэд дөхүүлэн "МНТ"-ны эртний монгол бичгийн эх бэлдэж байгаа бөгөөд өөрсдийн хийсэн тэрхүү "МНТ"-ны сэргээлтийн эхнээс хоёр хуудсыг танилцуулж байна.

¹⁴ Igor de Rachewiltz, *Index to the Secret history of the Mongols*, Bloomington, 1972, p. 129

¹⁵ Igor de Rachewiltz, *Index to the Secret history of the Mongols*, Bloomington, 1972, p. 133

Энд онцлон тэмдэглэх нэгэн зүйл бол эртний уйгуржин монгол үсгийг хэвийг МУИС-ийн багш Жамьянсүрэн 1312 оны модон бараар барласан Чойжи-Одсэрийн зохиолын хэвээр хичээнгүйлэн компьютерт хэв бүтээснээр "МНТ"-ны эхийг бэлдэж байгаа билээ.

אנחנו יחד ::

"

::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד — אנחנו יחד ::

אנחנו יחד — אנחנו יחד

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..

... ..